



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/25

Алтрага

**Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл  
хэрэгжүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан 2022 оны А/243, 2023 оны А/52 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон “Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2, 6.6, 6.7, 6.8, 6.10, 6.11 дахь хэсэг, Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хорооны 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01 дүгээр хуралдааны тэмдэглэлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хоршоо, жижиг, дунд үйлдвэрийг орон нутагт хөгжүүлэх арга хэмжээний хүрээнд шалгарсан дараах төслүүдийг санхүүжүүлж хэрэгжүүлсүгэй.

Үүнд: (сая.төг)

- 1.“Агар Мөрөн ЭНТ” хоршоо “Эрүүл мал” төсөл 18 сая
- 2.“Самгад, Алтраг хоёр” хоршоо “Хөнгөн ба даацын блок” төсөл 18 сая
- 3.“Жаахлайтын хөндий” хоршоо “Мал аж ахуйн шимийг бүрэн ашиглаж өрхийн орлогыг нэмэгдүүлэх” төсөл 9 сая
- 4.“Өндөр лүн” хоршоо “Цагаан идээ” төсөл 10 сая
- 5.“Хийморь сүрэг” хоршоо “Мал эмнэлгийн үйлчилгээ, эмийн сан” төсөл 10 сая
- 6.“Бөрлөг” хоршоо “Эко цай- Уламжлалт өв соёлоо хөгжүүлье” 10 сая

2.Төслийн зээлийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт тавих орон тооны бус зөвлөл (Д.Нямдэлгэр), Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтэн (Д.Долгормаа) нарт үүрэг болгосугай.

3.Зээлийн хөрөнгийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллахыг Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршоо хариуцсан мэргэжилтэн (Д.Долгормаа), Санхүүгийн албаны дарга (А.Дэлгэрмаа), Тамгын газрын даргын албан үүргийн түр орлон гүйцэтгэгч (М.Баттулга) нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ОДСЭР

Document-Zahiramg

**6729010059**